

СОЁМБО МЭДЭЭ

ҮЙЛ ЯВДАЛ

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 084,124 ДҮГЭЭР АНГИД АЖИЛЛАЛАА



Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Зэвсэгт хүчний 084, 124 дүгээр ангид өчигдөр ажиллалаа. Батлан хамгаалахын сайдыг Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн Хүндэт харуул ёслол төгөлдөр угтан авсны дараа тэрээр дээрх хоёр ангийн танилцуулгыг сонсож, сүүлийн жилүүдэд хийж хэрэгжүүлсэн томоохон ажил, цэргийн сургалт бэлтгэл, штабын бэлтгэл болон тулгамдаж буй асуудлыг нь сонсож, шийдвэрлэх арга замыг судлахаа мэдэгдсэн юм.

Мөн Батлан хамгаалахын сайд хоёр ангийн бүрэлдэхүүнтэй уулзаж, салбарын шинэчлэлтэй холбоотой хийж, хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээний талаар мэдээлэл хүргэж, цэргийн алба хаагчдыг Зэвсэгт хүчний 100 жилийн ойн медалиар шагнасан юм.

Батлан хамгаалахын сайдыг

дагалдаж Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, хурандаа Ж.Болдбаатар, Зэвсэгт хүчний Тусгай хүчний цэргийн штабын дарга, бригадын генерал Л.Гансэлэм, ЗХЖШ-ын Холбоо, мэдээлэл технологийн хэлтсийн дарга, хурандаа М.Золзаяа нар ажиллалаа.

Г.Сайханбаяр: РОТ, САЛААНЫ ЗАХИРАГЧ ГЭДЭГ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТОЛЬ БОЛСОН ЧУХАЛ АЛБА ЮМ

Зэвсэгт хүчний Жанжин штабаас Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын тэргүүний рот /батареи/, салааны захирагч нарын зөвлөгөөнийг 2 дахь өдрөө амжилттай явагдаж байна. Хоёр үе шаттай явагдаж байгаа тус зөвлөгөөний нэгдүгээр үе шатыг Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд өнгөрсөн сард дотооддоо зохион байгуулж, тэдгээр оролцогчдоос шалгарсан тэргүүний рот /батареи/, салааны захирагч нар нь хоёрдугаар шатны зөвлөгөөнд хамрагдаж байгаа юм.

Зөвлөгөөнд оролцогчдоод өчигдөр Засгийн газрын газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг нар уулзаж, тодорхой үүрэг даалгаврыг өглөө.

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр “Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн тэргүүний рот /батареи/, салааны захирагч нарын зөвлөгөөнд оролцож байгаа Та бүхэнтэй уулзаж байгаадаа баяртай байна. Энэхүү зөвлөгөө нь Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн өмнө тулгамдсан асуудлууд, тэдгээрийн шийдлийн талаар хэлэлцэх чухал ач холбогдолтой, өндөр үр дүнтэй ажил болно гэдэгт итгэлтэй байна.

Салаа, ротын захирагч гэдэг бол цэрэгт татагдсан залуучуудын дарга нь, багш нь, аав нь, ах нь байх ёстой. Эдгээр залуус Зэвсэгт хүчинд албаа хаагаад халагдахдаа эх оронч үзэл, хүмүүжлээр хүмүүжих, цэргийн бага мэргэжил эзэмшиж, аливаа нөхцөл байдлыг үнэлэх, түүнд тохирсон шийдвэр гаргах, захирах захирагдах ёс, хувийн хариуцлага, дэг журам, сахилга бат, ажил хэрэгч, зарчимч чанар, соёл, ёс зүйд суралцсан бүтээгч Монгол эр хүн болж төлөвших хүмүүжлийг албааас олж авдаг гэж би ойлгодог. Өнөөдөр Монгол Улсын хэмжээнд хүүхэд, залуусын хүмүүжлийн түвшин ямар байгаа вэ гэдэгт хүн бүр өөр өөрийн дүгнэлт гаргах нь мэдээжийн хэрэг. Энэ бүхэнд мэдрэмжтэй байж, ухаалгаар хандах хэрэгтэй. Ирээдүйд Монгол Улсын тусгаар тогтнолыг хамгаалах залуусыг бид бэлтгэж байгаа учир хариуцлага гэдэг зүйлийг эхэнд тавих ёстой. Үүний тулд бид хандлагаа өөрчлөх ёстой” хэмээгээд салбарын эрх зүйн шинэчлэл, энхийг дэмжих ажиллагаа болон эх орныхоо бүтээн байгуулалтад цэрэг дайчдын оруулж байгаа хувь нэмрийн талаар мэдээлэл өглөө.

Монгол Улсын цэргийн насны эрчүүдийн тодорхой хувь Зэвсэгт хүчин болон бусад төрийн цэргийн байгууллагад хугацаат цэргийн албыг хааж байна. Цэргийн

албыг хаахаар ирсэн залуусыг ирээдүйдээ итгэх итгэлтэй, зөв хүмүүжил төлөвшилттэй, бие бялдар, сэтгэл зүйн хаттай болгон төлөвшүүлэхэд салаа, ротын захирагч нар хамгийн чухал үүрэг гүйцэтгэх албан тушаалтан байдаг.



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСЫН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН	ЭДГЭРСЭН	НАС БАРСАН
55.067	48.674	259/13
ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
2510 (34)	250	2224

ТӨМӨР ЗАМЫГ БҮТЭЭН БАЙГУУЛАГЧДАД ТАЛАРХАЛ ДЭВШҮҮЛЖ, ШАГНАЛ ГАРДУУЛАВ

Орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн ойг тохиолдуулан Таван толгой-Зүүнбаян чиглэлийн “Шинэ төмөр зам” төслийн бүтээн байгуулалтад үүрэг гүйцэтгэсэн Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын офицер, ахлагч, ажилтан албан хаагч болоод төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудын зарим бүрэлдэхүүнд Төрийн одон, медаль гардуулах ёслолын ажиллагаа өчигдөр ЗХЖШ-ын жагсаалын талбайд боллоо.

Ёслолын арга хэмжээнд ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг тэргүүтэй ЗХЖШ, Төргийн цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газар, бусад төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын удирдлага оролцсон юм.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “Цэргийн гавьяаны улаан тугийн одон”-оор Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газрын Бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, хурандаа М.Энхбаяр, ахмад дайчид М.Баяраа, Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн захирагч, хурандаа Ц.Батсайхан нарын бүрэлдэхүүн, “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-оор “Гангүүр” ХХК-ийн ерөнхий захирал Б.Гантөмөр, “Өвөр залаат”

ХХК-ийн дэд захирал Ц.Бат-Эрдэнэ, Барилга-инженерийн цэргийн Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн төлөвлөлтийн мэргэжилтэн, хурандаа Д.Баасансүрэн, Зэвсэгт хүчний 017 дугаар ангийн захирагч, хурандаа Б.Дорждэрэм нар, “Алтан гадас” одонгоор Зэвсэгт хүчний 345 дугаар нэгтгэлийн захирагч, хурандаа Б.Хаш-Эрдэнэ, “Туулын гүүр далай” ХХК-ийн ерөнхий захирал Э.Баярчулуун, “Өвөр залаат” ХХК-ийн ерөнхий захирал Ц.Ганцэцэг, “Баткубик” ХХК-ийн ерөнхий захирал Д.Батбаяр нар хүртлээ.

Мөн “Цэргийн хүндэт медаль”-аар Зэвсэгт хүчний 7782 дугаар ангийн хийц угсрах мужаан, дэслэгч Э.Энх-Оргил, тус ангийн өөрөө буулгагчийн жолооч, ахлах ахлагч Х.Энхнасан, ахлах ахлагч Д.Батболд, Зэвсэгт хүчний 017 дугаар ангийн харуулчин О.Эрдэнэбямба нар, “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар Барилга-инженерийн цэргийн удирдах газрын Инженерийн дэд бүтцийн хэлтсийн дарга, дэслэгч Г.Ууганбаяр, тус хэлтсийн тоо хэмжээний инженер Ж.Чүлтэмнамдаг, Г.Хулан, Зэвсэгт хүчний 7782 дугаар ангийн нягтлан бодогч Д.Алтантуяа нарын бүрэлдэхүүн хүртсэнийг ЗХЖШ-ын даргын зөвлөлийн гишүүд гардуулан өгч, баяр хүргэлээ.



ХУРАНДАА ЦОЛ ОЛГОЛОО



ЗХЖШ-ын даргын тушаалаар ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын Энхийг дэмжих ажиллагааны хэлтсийн дарга, дэд хурандаа Т.Буянбат, УБХИС-ийн Цэргийн нэгдсэн дээд сургуулийн Агаарын цэргийн тэнхимийн дарга, дэд хурандаа Б.Ганзам, тус сургуулийн Артиллер, зэвсгийн

тэнхимийн дарга, дэд хурандаа Ц.Цэрэнбат, тус сургуулийн Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Аюулгүй байдал, батлан хамгаалах судлалын төвийн дарга, дэд хурандаа Б.Эрдэнэчимэг нарт албан тушаалын зэрэглэлийн хурандаа цол олголоо.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
18	3
ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
36	24
АФГАНИСТАН	
ӨДӨР	ШӨНӨ
30	17

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.844.00	2.855.00
EUR	3.438.00	3.544.00
CNY	443.00	447.90
RUB	38.00	40.20
JPY	25.71	26.60
KRW	2.43	2.61

ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 17
2021.05.28.
/БААСАН ГАРАГ/

ЗУНЫ ТЭРГҮҮН ХАРАГЧИН МОГОЙ САРЫН ДӨРВӨН НОГООН УЛААН ХУЛГАНА ӨДӨР

Үс засуулбал:
Өнгө зүс доройтно.
Наран ургах, шингэх:
05.00-20.39
Барилдлага:
Идэр
Шүтэн барилдлага:
Төрөн түгэхүй
Суудал:
Үс

Аргын тооллын 5 сарын 28, Сугар гараг. Билгийн тооллын 17, Гар одтой, улаан хулгана өдөр. Өдрийн наран 5 цаг 00 минутад мандан, 20 цаг 39 минутад жаргана. Тухайн өдөр луу, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд зөрэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эе эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ эхлэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, лусыг тахиx, хүүхэд үрчлэн авах, хур оруулах, дархны үйлд сайн. Улааны үйл, төлгөө тавих, морь уралдах, сэтгэлд сэтгэй газар очиход муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсоод мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

“ЭРҮҮЛ МЭНДИЙНХЭЭ ТӨЛӨӨ - ААХАНГАА ЯРНАЦЬЯ”

ДАРХЛААГ ДЭМЖИХ ЦАХИМ АЛХАЛТЫН

7 ХОНОГ

2021 оны 05 дугаар сарын 24-30 өдөр

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 169,610,769

Эдгэрсэн
Нийт: 151,322,785

Нас барсан
Нийт: 3,524,367

ҮЙЛ ЯВДАЛ

"БӨРТЭ" ТАВ ДАХЬ "ГАВЬЯАТ"-АА УГТАН АВЛАА



Бурхан багшийн их дүйчин өдөр буюу зуны тэргүүн сарын шинийн 15-ны билэгт сайн өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар "Бөртэ" Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын Үйлдвэрлэлийн албаны дарга Г.Оюунсүрэн "Аж

үйлдвэрийн гавьяат ажилтан" цолоор энгэрээ мялаалаа. Г.Оюунсүрэн нь 1985-1991 онд Техникийн их сургуулийг оёмол бүтээгдэхүүний технологич инженер мэргэжлээр төгссөн даруйдаа "Бөртэ" дүрэмт хувцасны оёдлын үйлдвэрт тооцоо гүйцэтгэгч, мастераар

ажлынгараагаа эхэлснээс хойш Батлан хамгаалах салбарт 30 орчим жил тууштай ажиллаж, цэргийн анги, байгууллагуудын дүрэмт хувцас, хэрэглэлийг үйлдвэрлэх үйлсэд мэргэжлийн болон удирдах ур чадвараа дайчлан ажиллаж байгаа боловсон хүчин юм.

БРИГАДЫН ГЕНЕРАЛ Б.БААТАР БҮС НУТГИЙН БАГА ХУРАЛД ЦАХИМААР ОРОЛЦОО

Зүүн өмнөд Азийн бодлогын бага хурал орнуудын холбооны бүсийн цахимаар явагдлаа. Бага хуралд нутгийн форумын 18 дахь удаагийн аюулгүй байдлын Монгол Улсын талаас Зэвсэгт хүчний аюулгүй байдлын хүчний Тусгай хүчний цэргийн

командлагч, бригадын генерал Б.Баатар оролцлоо. Форуммаар бүс нутгийн болон олон улсын аюулгүй байдалд тулгарч буй бэрхшээлүүдийг хэлэлцэхийн зэрэгцээ өнөөгийн болон ирээдүйн аюулгүй байдлын заналхийлэл, сорилтууд, дэд бүс нутаг дахь Ази-Номхон далайн бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлын төлөө харилцан итгэлцэл, хамтын ажиллагааны талаар оролцогч орнууд байр сууриа илэрхийлж, харилцан ярилцжээ.

Энэ удаагийн хурлыг Бруней Улсын Батлан хамгаалах яам зохион байгуулсан бөгөөд Зүүн өмнөд Азийн үндэстнүүдийн холбооны Бүс нутгийн форумын гишүүн болон Азийн бусад орны аюулгүй байдал, батлан хамгаалах салбарын удирдах албан тушаалтнууд оролцсон байна.



ЦЭРГИЙН АЛБА ХААСНЫ ТЭТГЭВЭРТ ГАРЧ БҮЙ АЛБА ХААГЧИДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭВ

Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалаас орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн ойг тохиолдуулан төрийн одон, медаль гардуулах, Цэргийн тангараг давтах, цэргийн алба хаасны тэтгэвэрт гарч байгаа офицерууд Байлдааны туганд хүндэтгэл үзүүлэх ёслолын арга хэмжээг өчигдөр зохион байгууллаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар "Цэргийн гавьяаны одон"-оор Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн ахлагч, тэргүүн ахлагч Д.Мөнхбаяр, Цэргийн сургалт, соёл хүмүүжлийн хэлтсийн мэдээлэл, соёл хүмүүжлийн офицер, дэд хурандаа Б.Золзаяа, "Зэвсэгт хүчин-100 жил" медалиар Удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн дарга, хурандаа О.Эрдэнэбаатар, Инженерийн дарга, хурандаа С.Содов, Цэргийн сургалт, соёл хүмүүжлийн хэлтсийн ахлах офицер, хурандаа Т.Тогмиддүүмий, Захиргааны удирдлагын хэлтсийн тушаал, шийдвэрийн хэрэгжилт хариуцсан офицер, дэд хурандаа С.Жаргалсайхан, Хүний нөөцийн хэлтсийн нөхөн хангалтын офицер, дэд хурандаа П.Чинзориг, хошууч Э.Эрдэнэбаатар нарын бүрэлдэхүүн шагнагдлаа.

Батлан хамгаалахын сайдын тушаалаар "Дайчин алдар II" медалиар Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн гал түймэр унтраах салааны жолооч, ахлах ахлагч Э.Батбаяр, "Эх орны төлөө III" хүндэт тэмдгээр тус командлалын



Хангалт үйлчилгээний тасгийн компьютер, сүлжээний техникч, ахлагч Э.Нямтөр, Удирдлагын байрын ротын авто, техник засварын тасгийн жолооч, ахлах ахлагч Б.Баттулга нар шагнагдсаныг Хуурай замын цэргийн штабын дарга, бригадын генерал Л.Онцгойбаяр гардуулан өгч, баяр хүргэсэн юм. Мөн энэ үеэр цэргийн

алба хаасны тэтгэвэрт гарч буй Удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн дарга, хурандаа О.Эрдэнэбаатар, Цэргийн сургалт, соёл хүмүүжлийн хэлтсийн мэдээлэл, соёл хүмүүжлийн офицер, дэд хурандаа Б.Золзаяа, Хангалт үйлчилгээний тасгийн дарга, дэд хурандаа Г.Гантуяа нар Байлдааны туганд хүндэтгэл үзүүлсэн юм.

САНХҮҮЧИД НОМЫН ДУУ СОНСЛОО



ЗХЖШ, Төрийн Инженерийн цэргийн удирдах газрын хэлтсийн бие бүрэлдэхүүн, Зэвсэгт хүчний нэгтгэл анги, салбаруудын санхүүгийн дарга, ахлах нягтлан бодогч, тооцооны нягтлан бодогч нарыг хамруулсан "Зэвсэгт хүчний санхүүгийн үйл ажиллагаанд холбогдох хууль, дүрэм, журмын хэрэгжилт, түүнийг хэрэгжүүлэхэд гарсан алдаа зөрчил, арилгах арга зам" сэдэвт цахим сургалт явагдлаа. Санхүү, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой Монгол Улсын хууль, түүнийг

хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан журам, зааврыг Зэвсэгт хүчний санхүүгийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэхэд үүрэг, оролцоо, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, аудит болон бусад санхүүгийн шалгалтаар ирлэрсэн зөрчил дутагдлыг арилгах, дахин гаргахгүй байх зорилгоор зохион байгуулагдлаа. Мөн Зэвсэгт хүчний ХШУГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, хурандаа Д.Ариунболд "Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудад хяналт шалгалтаар гарч буй нийтлэг алдаа зөрчилүүд, түүнийг

таслан зогсооход цаашид авч хэрэгжүүлэх ажлууд", төсвийн төлөвлөлт, санхүүжилтийн ахлах мэргэжилтэн, хурандаа П.Эрдэнбаяр "Төсвийн төсөл боловсруулах аргачлал, төсвийн бодлого хэмнэлтийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх", Төлбөр, тооцоо, төсвийн гүйцэтгэлийн мэргэжилтэн, дэд хурандаа Х.Чанцалмаа "шилэн дансны хуулийн хэрэгжилт" зэрэг сэдвээр лекц, ЗХЖШ-ын ЗУХ-ийн хуулийн зөвлөх, ахлах мэргэжилтэн, ахмад А.Эрдэнэманх цэргийн алба хаагчдын сахилга, хариуцлага, өнөөгийн байдлын талаар мэдээлэл өгөв.

1200 УЛИАС, 300 ШАР ХАЙС ТАРИЛАА

Зэвсэгт хүчний 353 дугаар анги

"Мод тарих үндэсний өдөр"-ийг тохиолдуулан ангийн байрлалд 1200 улиас, 300 шар хайс мод тарилаа. Энэ нь ажлын байрныхаа орчин тойронд агаарын бохирдлыг бууруулж, эх орон, байгаль дэлхийгээ нөхөн сэргээж, хайрладаг уламжлалт монгол зан заншлаа дээдэлж, байгалиа хамгаалахад гар бие оролцох нөхцөлийг бүрдүүлэх онцгой ач холбогдолтой арга хэмжээ болж өнгөрөв. Тус арга хэмжээнд ангийн бие бүрэлдэхүүн болон энгийн ажилчин алба хаагчид, салбар, нэгжүүд идэвхтэй хамрагдлаа.



ШАГНАЛ БАС ХҮНДЭТГЭЛ



Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэж хөгжсөний 100 жилийн ойн баяр тохиож байгаа энэхүү бахархалт өдрүүдийн хүрээнд ангийн алба хаагчдыг эх орон, төр ард, түмэндээ үнэнчээр зүтгэснийг нь үнэлж төрийн одон, медаль болон салбарын шагналаар шагналаа. Тухайлбал, Цэргийн гавьяаны одонгоор дэд хурандаа Д.Ганбаатар, Цэргийн хүндэт медалиар дэд хурандаа О.Амарсанаа, хошууч Б.Дашренчин, ахлах дэслэгч Л.Насантогтох, Р.Дэлгэрмаа, нарын 11-н цэргийн алба хаагчийг, Хөдөлмөрийн хүндэт медалиар Ц.Сүндэрээ, М.Отгон нарыг Зэвсэгт хүчний 100 жилийн ойн медалиар 145 алба хаагч шагнаж, шагналын хур буусан өдөр боллоо.

Мөн тус өдөр Зэвсэгт хүчин хэмээх их айлын нэгэн гишүүн нь болж, энэхүү албандаа үүргээ нэр төртэйгөөр гүйцэтгээд гавьяаныхаа амралтад гарч буй цэргийн алба хаагчиддаа хүндэтгэл үзүүлж, цаашдынх нь ажил, амьдралд нь амжилт бүтээл, аз жаргалыг хүсэн ерөөлөө.

Ахмад Б.НАНДИНЦЭЦЭГ

ЦЭРГИЙН ХҮРЭЭ, ХОТХОНЫ ЦЭРГИЙН ЦАГДААГИЙН САЛБАРЫГ БАЙГУУЛЛАА

ЗХЖШ-ын даргын тушаалаар Цэргийн хүрээ, хотхоны цэргийн цагдаагийн салбарыг байгуулж, бие бүрэлдэхүүнийг томилон ажиллуулж эхлээд байна. Үүнтэй холбогдуулан шинээр томилогдсон Цэргийн хүрээ, хотхоны цэргийн цагдаагийн бүрэлдэхүүнтэй ЗХЖШ-ын Цэргийн албаны хэлтэс, цэргийн цагдаагийн дарга, хурандаа Д.Адъяабазар, цэргийн цагдаа хариуцсан мэргэжилтэн, хошууч Б.Аваадорж нар өнгөрсөн мягмар гаргарт цахимаар хуралдлаа. Хурлаар хурандаа Д.Адъяабазар Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн бие бүрэлдэхүүнд Цэргийн нийтлэг дүрмийг мөрдүүлэх, аливаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд цэргийн цагдаа



нарын үүрэг их гэдгийг онцлоод БХЯ, ЗХЖШ-ын удирдлагын зүгээс итгэл хүлээлгэж буйг уламжиллаа. Мөн үүрэг гүйцэтгэлтийн онцлог, цаашид

хэрэгжүүлэх арга хэмжээ, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарын удирдлагатай хэрхэн хамтран ажиллах талаар үүрэг чиглэл өгсөн юм.